

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/197

**БАЯНХОНГОР СУМЫН 14 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ө.ОЮУНГЭРЭЛ ТАНАА**

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Байгууллагын нярав бараа материалын тайланг зохих стандартын дагуу гаргаагүй байхад дарга, нягтлан бодогч нар хяналт тавиагүй,
- Цалингийн зардлын хэмнэлтийг урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан,
- Өмнөх оны аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан орон тоонд багтаан ажиллах зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй,
- 2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан байна.

• 005020531

Дээрх нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,893,254.30</u>	<u>38,276,454.23</u>
33	АВЛАГА	12,600.72	4,464,720.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,600.72	00.00
335	Бусад авлага	00.00	4,464,720.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	4,464,720.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,880,653.58	33,811,734.23
351	Түүхий эд материал	4,267,276.00	12,017,438.00
35110	Тусгай зориулалттай материал	3,777,276.00	8,638,438.00
35130	Эм боох материал	490,000.00	3,379,000.00
354	Хангамжийн материал	19,613,377.58	21,794,296.23
35410	Бичиг хэргийн материал	910,950.00	1,086,050.00
35420	Аж ахуйн материал	13,025,619.00	12,762,127.00
35450	Барилгын засварын материал	1,367,000.00	1,411,000.00
35460	Хүнсний материал	108.58	1,860,819.23
35470	Бусад хангамжийн материал	4,309,700.00	4,674,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>352,666,245.69</u>	<u>351,877,782.34</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	352,666,245.69	351,877,782.34
392	Биет хөрөнгө	351,940,245.82	351,443,282.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	335,527,366.00	335,527,366.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,187,679.30	-20,899,731.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,103,370.00	38,294,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,899,680.07	-19,939,583.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,983,534.00	22,983,534.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,586,664.81	-14,108,453.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	9,947,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-621,718.74
39217	Ном	00.00	260,000.00
393	Биет бус хөрөнгө	725,999.87	434,499.83
39301	Програм хангамж	1,408,000.00	1,408,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-682,000.13	-973,500.17
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>376,559,499.99</u>	<u>390,154,236.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>89,033.21</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	89,033.21
413	Өглөг	00.00	89,033.21
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	89,033.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>376,559,499.99</u>	<u>390,065,203.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	376,559,499.99	390,065,203.36
512	Хуримтлагдсан үр дүн	184,292,946.62	197,798,649.99
51210	Өмнөх үеийн үр дүн	184,292,946.62	184,292,946.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	13,505,703.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,266,553.37	192,266,553.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>376,559,499.99</u>	<u>390,154,236.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	281,527,600.00	318,966,290.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,445,500.00	21,729,662.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,445,500.00	21,729,662.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,445,500.00	21,729,662.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,445,500.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/		16,138,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/		5,591,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275,082,100.00	297,236,628.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	258,405,900.00	277,781,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	258,405,900.00	277,781,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	4,953,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,953,140.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,676,200.00	14,502,288.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,676,200.00	14,502,288.44
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280,234,456.65	305,460,587.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,234,456.65	305,460,587.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	277,302,059.56	270,515,736.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,545,844.19	193,586,555.28
210101	Үндсэн цалин	148,324,476.28	157,265,345.08
210102	Нэмэгдэл	30,559,263.59	19,394,320.22
210104	Урамшуулал	7,853,123.05	16,926,889.98
210105	Гэрээт ажлын хөлс	808,981.27	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,476,500.00	25,426,752.49
210201	Тэтгэврийн даатгал	15,964,000.00	17,331,552.49
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,100.00	2,001,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,500.00	1,601,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,800.00	400,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,767,100.00	4,091,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,816,064.00	14,002,288.44
210301	Гэрэл, цахилгаан	6,005,046.00	5,358,456.44
210302	Түлш, халаалт	3,814,918.00	3,592,512.00
210303	Цэвэр, бохир ус	4,996,100.00	5,051,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,901,593.00	4,925,611.00
210401	Бичиг хэрэг	1,247,900.00	544,700.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	866,793.00	1,262,216.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	358,000.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,828,900.00	1,908,695.00
2105	Нормативт зардал	26,811,021.28	10,283,189.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	624,200.00	1,019,000.00
210502	Хоол, хүнс	26,186,821.28	9,264,189.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,169,700.00	2,456,977.00
210604	Урсгал засвар	2,169,700.00	2,456,977.00
2107	Томилолт, зочны зардал	103,600.00	75,900.00

**Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	103,600.00	75,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,900.00	1,553,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,900.00	967,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,006,837.09	18,204,963.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,600.00	840,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000.00	178,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,716,237.09	17,186,963.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,932,397.09	34,944,850.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,700.00	5,034,440.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,953,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,700.00	81,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	371,416.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	371,416.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,450,281.09	29,910,410.16
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,450,281.09	29,910,410.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,293,143.35</u>	<u>13,505,703.37</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,293,143.35</u>	<u>13,505,703.37</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,999,803.27	375,266,356.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,999,803.27	375,266,356.64
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	184,292,946.62	376,559,499.99
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	184,292,946.62	376,559,499.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	192,266,553.37	184,292,946.62	376,559,499.99
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	13,505,703.37	13,505,703.37
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	197,798,649.99	390,065,203.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	275,082,100.00	297,236,628.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275,082,100.00	297,236,628.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	258,405,900.00	277,781,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	258,405,900.00	277,781,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	4,953,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,953,140.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,676,200.00	14,502,288.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,676,200.00	14,502,288.44
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	267,022,100.00	296,976,628.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,022,100.00	296,976,628.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,089,702.91	262,031,778.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,527,543.91	193,497,522.07
210101	Үндсэн цалин	149,433,913.34	157,176,311.87
210102	Нэмэгдэл	23,299,675.52	19,394,320.22
210104	Урамшуулал	13,690,700.76	16,926,889.98
210105	Гэрээт ажлын хөлс	1,103,254.29	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,476,500.00	25,414,151.77
210201	Тэтгэврийн даатгал	15,964,000.00	17,407,151.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,100.00	2,001,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,500.00	1,601,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,800.00	400,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,767,100.00	4,003,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,304,784.00	14,002,288.44
210301	Гэрэл, цахилгаан	6,493,766.00	5,358,456.44
210302	Түлш, халаалт	3,814,918.00	3,592,512.00
210303	Цэвэр, бохир ус	4,996,100.00	5,051,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,498,475.00	4,228,316.00
210401	Бичиг хэрэг	99,900.00	173,200.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,084,875.00	1,262,216.00
210404	Ном, хэвлэл	51,700.00	40,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	358,000.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,304,000.00	1,542,200.00
2105	Нормативт зардал	26,206,600.00	13,507,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	651,700.00	2,018,000.00
210502	Хоол, хүнс	23,824,900.00	11,124,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,730,000.00	364,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,169,700.00	7,024,700.00

**Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	2,169,700.00	7,024,700.00
2107	Томиллолт, зочны зардал	103,600.00	75,900.00
210702	Дотоод албан томиллолт	103,600.00	75,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,900.00	1,630,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,900.00	1,044,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,001,600.00	2,650,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	616,100.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,385,500.00	650,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,932,397.09	34,944,850.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,700.00	5,034,440.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,953,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	110,700.00	81,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	371,416.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	371,416.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,450,281.09	29,910,410.16
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,450,281.09	29,910,410.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,060,000.00	260,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,060,000.00	260,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,060,000.00	260,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,060,000.00	260,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,060,000.00	260,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,060,000.00	-260,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	298,143,300.00	262,373,078.28	35,770,221.72	88.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	298,143,300.00	262,373,078.28	35,770,221.72	88.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,062,000.00	262,291,778.28	35,770,221.72	88.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,794,700.00	193,497,522.07	16,297,177.93	92.23
210101	Үндсэн цалин	173,218,100.00	157,176,311.87	16,041,788.13	90.74
210102	Нэмэгдэл	19,621,100.00	19,394,320.22	226,779.78	98.84
210104	Урамшуулал	16,955,500.00	16,926,889.98	28,610.02	99.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,623,600.00	25,414,151.77	3,209,448.23	88.79
210201	Тэтгэврийн даатгал	20,616,600.00	17,407,151.77	3,209,448.23	84.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,862,100.00	14,002,288.44	5,859,811.56	70.50
210301	Гэрэл, цахилгаан	8,970,500.00	5,358,456.44	3,612,043.56	59.73
210302	Түлш, халаалт	4,291,600.00	3,592,512.00	699,088.00	83.71
210303	Цэвэр, бохир ус	6,600,000.00	5,051,320.00	1,548,680.00	76.54
2104	Хангамж, бараа материалын зардал	4,882,500.00	4,488,316.00	394,184.00	91.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,366,400.00	1,262,216.00	104,184.00	92.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	210,000.00	290,000.00	42.00
2105	Нормативт зардал	23,513,600.00	13,507,500.00	10,006,100.00	57.45
210502	Хоол, хүнс	21,131,000.00	11,124,900.00	10,006,100.00	52.65
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,634,300.00	1,630,800.00	3,500.00	99.79
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	236,500.00	3,500.00	98.54
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	298,143,300.00	262,373,078.28	35,770,221.72	88.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	277,781,200.00	247,870,789.84	29,910,410.16	89.23
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,781,200.00	247,870,789.84	29,910,410.16	89.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,362,100.00	14,502,288.44	5,859,811.56	71.22
132001	Орон нутгийн төсвөөс	20,362,100.00	14,502,288.44	5,859,811.56	71.22
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	20.00	-02.00	111.11
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	10.00	-01.00	111.11
620003	Үйлчлэх ажилтан	08.00	09.00	-01.00	112.50
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	108.00	88.00	20.00	81.48
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	108.00	88.00	20.00	81.48
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	20.00	-02.00	111.11
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	09.00	10.00	-01.00	111.11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	10.00	-01.00	111.11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,953,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,953,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4953140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,953,140.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,140.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4953140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,953,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,953,140.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, эд хөрөнгийн тооллогыг бүрэн хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулах, шилэн дансны цахим хуудаст дутуу оруулсан мэдээллийг мэдээлэх, цалингийн зардлын бичилтийг зөв бичих зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 14/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг цэцэрлэгийн эрхлэгч Ө.Оюунгэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Оюунгэрэл нар зурж, нярваар 2021 оны 3-6 сард Б.Баясаа, 1-2, 7-12 сард Э.Оюунбилэг ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгт 2021 онд ахлах бүлэгт 26, бэлтгэл 2 бүлэгт 43, гэр цэцэрлэгийн холимог бүлэгт 19, нийт 88 хүүхэд хамрагдахаас танхимаар 72, цахимаар 16 хүүхэд хамрагдсан ба үндсэн 3 бүлэг байгууллагын байранд, 1 бүлэг Дуурсах 3 дугаар багт гэрээр хичээллэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллага нягтлан бодох бүртгэлийг 2018 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтөлсөн байна.

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 280,234.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,802.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,241.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 305,460.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,054.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг

төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,443.7 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 390,154.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 13,594.7 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	3	5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,893.3	38,276.5	14,383.2
Авлага	12.6	4,464.7	4,452.1
Бараа материал	23,880.7	33,811.7	9,931.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	352,666.2	351,877.8	(788.5)
Үндсэн хөрөнгө	392,022.3	408,420.8	16,398.5
Хуримтлагдсан элэгдэл	(39,356.0)	(56,543.0)	(17,187.0)
Нийт хөрөнгө	376,559.5	390,154.2	13,594.7
Өр төлбөр	-	89.0	89.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	376,559.5	390,065.2	13,505.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	376,559.5	390,154.2	13,594.7

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

“Навтгар хайрхан” ХХК-д цэцэрлэгийн хүзүүвч засварлах материалын үнийн 4,452.1 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэснээс оны эцэст 4,452.1 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,811.7 мянган төгрөг болж өмнөх оноос 9,931.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 20,876.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 5,591.2 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 16,536.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Оны эхэнд бүртгэлтэй 392,022.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж тайлант онд төсвийн хөрөнгөөр 260.0 мянган төгрөгийн ном худалдан авч, аймгийн БСУГ-аас 6,191.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, өнгөт принтер, 2 дугаар хоолны тогоо, Баянхонгор сумын ОНХС-аас 9,947.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайг хандиваар ирснийг бүртгэлд авч, оны эцэст 408,420.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 13,505.7 мянган төгрөгөөр өссөн 390,065.2 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг 2021 оны төсвийн төлөвлөлтийг 457,512.2 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 302,491.6 мянган төгрөгөөр баталсан ба 2021 оны 7 дугаар сард 298,143.3 мянган төгрөгөөр баталж, 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийсэн байна.

Анхны батлагдсан төсөв	2021 оны 12 сард зохицуулалт хийсэн төсөв
302,491.6	298,143.3

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр авахаар батлагдсан 277,781.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авахаар батлагдсан 20,362.1 мянган төгрөгийн дэмжлэгээс 5,859.7 мянган төгрөгөөр дутуу авч, нийт 262,373.1 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 262,373.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 29,910.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1 багшийн 5 жилийн тэтгэмжид 4,953.1 мянган төгрөгийн санхүүжилт орж, байгууллагын даргын тушаалаар олгосныг тайланд үнэн зөв тусгасан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын даргын 2021.10.28-ний өдрийн 14/63 дугаар албан бичгээр аймгийн СТСХ-т цэцэрлэгийн хүзүүвчид засвар хийх зардлын тооцоог хүргүүлж, 11 дүгээр сард тус зардлыг цалингийн зардлын хэмнэлтээс олгох эрхийг нээж өгөн, 2021.11.29-ний өдөр "Навтгар хайрхан" ХХК-д шилжүүлж, авлагаар бүртгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт арга хэмжээний хүрээнд 13 чиглэлийн дагуу 49 ажил төлөвлөн ажилласанаас ковид халдварт өвчлөлийн улмаас хийгдээгүй ажил 4, хэрэгжсэн 45 ажил үйлчилгээг жилийн эцсийн байдлаар Баянхонгор сумын Засаг дарга 93%-иар үнэлж дүгнэсэн.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, бараа материалын тайланг нярав сараар гаргаагүй, өмнөх оны аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан орон тоонд багтаан ажиллах зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй,

2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан, цалингийн зардлын хэмнэлтийг урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Үнэлгээ", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дүгнэлтийг хязгаарлав.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 304,546.9 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс байгууллагын даргын 2021.10.19-ний өдрийн Б/18 дугаар тушаалыг мэдээлээгүй, 12 сарын санхүүжилтийг 2,393.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант онд бичиг хэргийн зардалд батлагдсан 173.2 мянган төгрөгийг зарцуулж, "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" заалтыг мөрдөж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгч, 492.5 мянган төлбөрийн акт тогтоожээ. Шалгагдагч байгууллага төлбөрийн актыг 2021.03.31-ний өдөр барагдуулж, 2021.06.28-ний өдрийн 14/32 дугаартай албан бичгээр

төрийн аудитын байгууллагад зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна. Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах, батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг биелүүлээгүй, 2021 онд зөрчил дахин илэрсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын үйл ажиллагааг батлагдсан орон тоонд багтаан явуулсан эсэхийг анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25,542.5 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 5,859.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 4,464.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд үнийн дүнгүй албан шаардлага өгч, 15,217.9 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.

1. Тайлант онд 298,1443.3 мянган төгрөгийн төсөв баталсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 292,283.5 мянган төгрөгөөр буюу 5,859.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын 2021.10.28-ний өдрийн 14/63 дугаар албан бичгээр аймгийн СТСХ-т цэцэрлэгийн хүзүүвчид засвар хийх зардлын тооцоог хүргүүлж, 11 дүгээр сард тус зардлыг цалингийн зардлын хэмнэлтээс олгох эрхийг нээж өгөн,

2. 2021.11.29-ний өдөр “Навтар хайрхан” ХХК-д шилжүүлж, материалыг аваагүй тул авлагаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.2 Албан шаардлага

1. Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Төсвийн төлөвлөлтөд орон тоо, цалингийн санг үндэслэлтэй төлөвлөж, орон тоо батлагдаагүй байхад илүү орон тоогоор ажиллуулж байгааг цаашид зогсоож, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах” зөвлөмжийг өгсөн байхад 2021 онд батлагдсан орон тооноос 2 орон тоог илүү ажиллуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Байгууллагын нярав хүнсний материалаас бусад бараа материалын орлого, зардлыг тусгасан тайланг буруу гаргасан байхад байгууллагын дарга, нягтлан бодогч нар хяналт тавиагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Ерөнхий нягтлан бодогчэд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд бичиг хэргийн зардалд батлагдсан 173.2 мянган төгрөгийг зарцуулж, “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.9 дэх “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: 2010 онд орлогод бүртгэсэн нэг бүр нь 1749.5 мянган төгрөгийн үнэ бүхий 5,248.5 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютерын ашиглах жилийг 0-ээр оруулснаас тухайн хөрөнгөд элэгдэл бодогдоогүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Зөөврийн компьютерыг анх ашиглалтад орсон хугацааг тооцож ашиглах жилийг санхүүгийн программд оруулан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу элэгдлийг тооцох.

3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тооллогоор 293.3 мянган төгрөгийн номыг тоолоогүй, нягтлан бодогч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг нүд үзэн тоолж, тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогч данс бүрээр тооцоо бодсон актыг үйлдэж, архивлах.

4. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст багш Ш.Ичинноровт 4,953.1 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгох байгууллагын даргын 2021.10.19-ний өдрийн Б/18 дугаар тушаалыг мэдээлээгүй, 12 сарын санхүүжилтийг 2,393.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын даргын Б/18 дугаар тушаалыг мэдээлж, 12 дугаар сарын орлогыг 2,393.0 мянган төгрөгөөр залруулж мэдээлэх

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Албан хаагчдаас 2,330.0 мянган төгрөгийн хамтын сангийн суутгал суутгаж, авлагаар бүртгэж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан

"Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6 дахь цалингийн зардлын бүртгэлийг мөрдөж ажиллаагүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6 дахь цалингийн зардлын бүртгэлийн дагуу хамтын сангийн суутгалыг өглөгийн дансаар бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг	9	25,542.4	1	5,859.80	1	4464.7	2	-	5	15,217.9

---oOo---